

Холбох хэрэглүүрийн тухай

11-р анги

Холбох хэрэглүүрийн тухай товч

Өгүүлбэрүүд холбогдож цогцолбор, цогцолборууд хэлхэлдэж мөчлөгийг бий болгоно.

Цогцолборыг бүрдүүлэгч өгүүлбэрүүд нь:

- Нөхцөлөөр
- Үгийн үндсээр
- Холбох үгээр
- “Гэ” , “хэмээ” үйл үгээр тус тус холбогддог.

Монгол хэлний холбох хэрэглүүр ихэвчлэн өгүүлбэрийн заагт байна.

Нөхцөлөөр холбогдсон өгүүлбэрийн жишээ:

1. Монгол эхийн гал уураг ховдогло**н** хөхө**ж**, хонины хөдсөн өлгийд үнэгчил**ж** торнисон.
2. Аавдаа адуу манах**ыг** заа**ж**, ээждээ утас ээрэх**ийг** сургана.

Үргэлжлэл

Холбох үгээр холбогдсон өгүүлбэрийн жишээ:

1. Ухаантан мэргэд хэдий эрдэмтэй **боловч**

Улам улам мэргэжихийн **тул** ном судар цуглуульюу.

2. Алс хол мөрөө санах **бөгөөд** сэрэмжтэй.

Уурлах цаан **бөгөөд** зовлонг тэсэгч

Ааль зан нь тотуун **бөгөөд** хичээнгүй

Адаг боол хүн **боловч** дээд ноён больюу.

Үндсээр холбогдсон жишээ :

1. Малд **дургүй** хүн гарсаар хашхирна.

Галд **дургүй** хүн очсоор чичнэ.

“Гэ”, “хэмээ” үйл үгээр холбогдсон өгүүлбэрийн жишээ:

1. Өгнө **гэхэд** өрвөс хийнэ.

Авна **гэхэд** арвас хийнэ.

2. Үгийн нүдийг олж бичнэ **гэдэг** түүнийг зөв сонгоно **гэсэн** хэрэг.

Холбох үг

Холбох үг нь үгийг үгтэй, үгийг холбоо үгтэй, өгүүлбэрийг өгүүлбэртэй, цогцолборыг цогцолбортой холбон найруулдаг.

Холбох үг нь найруулгын үүрэг гүйцэтгэхдээ үг , холбоо үг, өгүүлбэрийг **зэрэгцүүлэх, эсрэгцүүлэх, нөхцөлдүүлэх, лавшруулах** утгаар холбож найруулгын тодорхой харьцаа үүсгэн өнгө аясыг илэрхийлдэг.

Холбох үгийн утгын ангилал

1. Зэрэгцүүлэх утгатай холбох үг: Үүнийг салгах, ялгах утгатай гэж ангилдаг. ба, бөгөөд, хийгээд, агаад, буюу, болон, боловч
2. Эсрэгцүүлэх утгатай холбох үг: гэтэл, гэвч, гэлээ ч, гэсэн ч, гэхдээ, харин, эсвэл, нэг бол, үгүй бол, атал, тэгтэл, тэглээ ч гэсэн
3. Нөхцөлдүүлэх буюу шалтгааны утгатай холбох үг: Иймээс, ийм учраас, тулд, учир, улмаас, тиймээс, мөнхүү, тийнхүү, ингэж, ингээд, ингэхлээр, иймд, иймийн тул, тиймийн тул, нэгдүгээрт, хэрэв, энэ мэтээр, үүнээс үзэхэд, тэгэхлээр гэх мэт
4. Лавшруулан холбох утгатай үг: мөн, түүнчлэн, үүнчлэн, үүнээс гадна, түүнээс гадна, нөгөө талаар, цаашилбал, тодруулбал, үүнээс уламжлан, үүний зэрэгцээгээр, улмаар, тэр ч байтугай, үл барам, барахгүй, өөрөөр хэлбэл бас.

Холбох үг

Үг хоорондын
холбоос

Өгүүлбэрийн
дотоод
холбоос

Өгүүлбэрийн
гадаад
холбоос

1. Үг хоорондын холбоос:

Үг, холбоо үгийг хооронд нь холбож зэрэгцүүлэх үүрэгтэй холбоос юм.
Жишээ нь: ба, болоод, болон, бөгөөд, буюу, хийгээд гэх мэт .

- Өгүүлбэрийн дотоод холбоос

Энгийн өгүүлбэрийн доторх энгийн өгүүлбэрүүдийг холбоно.

Жишээ нь: болоод, бөгөөд, ба, болон, хийгээд, мөн, улмаар, аль эсвэл, нэг бол, үгүй бол, гэх мэт

- Өгүүлбэрийн гадаад холбоос

Өгүүлбэрийг өгүүлбэртэй, нэг цогцолборыг нөгөө цогцолбортой холбож утгын уялдаа холбоог тодорхой болгодог.

Жишээ нь: бас, гэтэл, гэхдээ, тэгэхдээ, иймээс, тиймээс, ийнхүү, ийм учраас үүнчлэн, түүнчлэн , ингэхлээр, тэгэхлээр, тэгвэл, энэ мэтээр, өөрөөр хэлбэл, тодруулбал гэх мэт